

ТӨРИЙН АЛБАН ХААГЧЫН ЁС ЗҮЙН БАЙДАЛ:

АНУ ба Монгол Улс

Томас Шевори доктор

АНУ, Итака коллеж, Улс төрийн шинжлэх ухааны тэнхим

Д.Ундрах докторант

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Түлхүүр үгс: төрийн албаны бүтэц, төрийн албан хаагчид болон сонгуульд албан хаагчдын соёл, ёс зүйн кодекс, авилгал, олон нийтийн санаа бодол

Монгол төрийн алба, түүний бүтэц бүрэлдхүүн

Монгол улсад төрийн албыг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, түмэн олондоо хоёргүй сэтгэлээр үйлчлэх үүрэг хүлээсэн албан хаагчдын нэр хүнд, ажлын хариуцлагаар Монгол төрд өгөх үнэлгээ, төрийн албаны нүүр царай харагдах ёстой. Асуудлыг тодруулах үүднээс цөөхөн баримт дурдья. Хуулинд, Монгол улсад төрийн албыг:




ангилах ба үүнээс төрийн захиргаа болон тусгай албыг төрийн жинхэнэ алба гэж үзнэ хэмээн²⁹ заажээ.

Төрийн албаны хуулинд төрийн албаны болон албан тушаалын ангилал, түүний төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, нийтлэг үүргийг тусган өгсөн байдаг. Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд нийтлэг үүрэг, нийтлэг эрх, жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, энэхүү ангиллын албан тушаалыг эрхлэх болзол журам, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх, албанаас чөлөөлөх, халах, шилжүүлэх, сарилгын шийтгэл


²⁹ Төрийн албаны тухай Хууль. 1 бүлэг. 3 зүйл. 2002-06-28.

ноогдуулах журмыг тогтоосон байдаг бол, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр олгох, шагнал урамшил, олгох тусламж, тэтгэвэр тэтгэмжийг мөн бүгдэд хамрах байдлаар тогтоосон байна.


2001 оны 1 сарын 1-ны байдлаар, нийт 139062 төрийн албан хаагчид доорхи бүтцийн дагуу ажиллаж байжээ:



2007 оны 10 сарын 08-ны байдлаар 146573 төрийн албан хаагчид:



Эндээс харахад зургаан жилийн хугацаанд нийт төрийн албан хаагчдын тоо 5,4%-иар өссөн үзүүлэлт харагдаж байна. Харин 2009 оны 1 сарын 1-ны байдлаар нийт 144049 төрийн албан хаагчид ажиллаж байгаагаас:



Тэгэхээр “төр, ард түмэндээ үйлчлэхдээ шударга ёсыг дээдлэн, хүнд сурталд авталгүй, хүнлэг энэрэнгүй, ардчилсан зарчмыг баримтлан ажиллах ёстой”³⁰ Монгол төрийн албан хаагчдын тоо харьцангуй тогтвортой хэмжээнд байгаа нь харагдаж байгаа бол, төрийн албыг цалгардуулалгүй урагшлуулах эдгээр эрхэм хүмүүс үүргээ хэрхэн нэр төртэй биелүүлж, Монгол төрийн нүүр царай болж буй талаар авч үзье.

Юуны түрүүн төрийн албанд үйлчилж буй үндсэн хоёр зарчим дээр суурилсан тогтолцоо байдагыг энд дурдья. Энэ нь: “Мерит” буюу туршлага, гавьяа зүтгэлийг нь үнэлсэн, төрд тогтвортой үйлчлэх зарчим “Спойл” буюу олз хуваарилах зарчим юм.

“Мерит” тогтолцооны үед улстөрийн сонгуулиар төрийн мэргэшсэн албан хаагчдын бүрэлдхүүнийг шинээр бүрдүүлэх шаардлага гардаггүй тул төрийн үйл ажиллагааны залгамжлагдах шинж хадгалагдаж, тогтвортой байдал бий болсоноор, үр дүнгийн коэффициент өндөрсдөг. Улмаар, албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэнээр, ажилдаа идэвх зүтгэлтэй, өөриймсөг сэтгэлээр хандах, мэргэшлийн өндөр төвшинд хүрэх бололцоо бий болдог байна. Гэхдээ энэ нь төрийн улстөрийн албан тушаалд улстөрөөс хамааралтай “Спойл” зарчим үйлчлэхийг үгүйсгэсэн хэрэг биш бөгөөд харин үүний зохимжит нэгдлийг хангахын чухлыг сануулж байгаа юм. Гэвч харамсалтай нь бодит байдал дээр, улстөрийн сонгуулиар төрийн удирдлагад гарсан зарим улстөрийн хүчин төрийн мэргэшсэн албан хаагчын багийг “удирдлага солигдсон” нэрээр өөр өөрийн хүнээр өөрчилсөнөөр “Спойл” тогтолцооны үед гарч болох гажуудал бий болж, нийгэм дэх сөрөг нөлөө нь үргэлжилсээр байна³¹. Бий болсон ужиг хандлагыг арилгах үүднээс, Төрийн албан хаагчдын мэргэжлийн шалгалтыг Төрийн Албаны Зөвлөл (1995-2002 хүртэл Төрийн Захиргааны Албаны Зөвлөл)-өөс зохион байгуулах болсон нь төрийн албан хаагчдыг ажил мэргэжлийн хувьд чанаржуулах, мэргэшүүлэхэд тодорхой хувь нэмрээ өгсөн алхам болж дэлхийн нийтэд тархсан түгээмэл жишиг үйл явцыг Монгол улсад үр дүнтэй, бүтээлчээр түгээх ажлын эхлэл болж байгаа ч, учир дутагдал оршсоор байгааг хэлэх нь зүйтэй.

Төр, түүний албан хаагчдын ёсзүйн асуудлыг өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудад хэрхэн авч үздэгийг мэдэх, тэдгээрийн хөгжилтэй харьцуулан судлах нь бидний өмнө тулгарч болох бэрхшээлийг урьдчилан харж тойрч гарах, нэгэнт бий болсон асуудлыг шийдвэрлэх гарц хайхад тустай болох болов уу хэмээх үүднээс АНУ-д төрийн албан хаагчдын ёсзүйн асуудлыг хэрхэн ойлгож, үнэлж дүгнэж буй хийгээд тэдгээрийн улс төрийн ёсзүйгээс ялгарах талыг нээн харуулж өөрийн орны жишээн дээр харьцуулан үзэхийг оролдлоо.

Төрийн албан хаагчийн ёсзүй

АНУ: Хоёр соёл

Түүхэн тодорхой цаг хугацаанд, удаан хугацаагаар үргэлжлэх шат дараалсан шинэтгэлийн дүнд АНУ-д төрийн захиргааны аппаратыг намын

³⁰ “Төрийн албан хаагчийн ёсзүйн хэм хэмжээний тухай дүрэм”

³¹ В. Удвал. “Удирдлагын эрхзүй”, УБ. 1999., 73-74 тал

системээс зааглаж чадсан. Яг хэрэг дээрээ, тэрхүү шинэтгэлийн эцэст захиргааны ба улстөрийн соёл хэмээгдэх өөр өөрийн өнгө төрхтэй хоёр соёлыг бий болгоход чиглэсэн билээ. Төрийн албаны тогтолцоо нэрийн дор, төрийн албан хаагчдыг дор хаяж л доод болон дунд шатанд, өөрийн үүрэгт ажлаа тасралтгүй хэрэгжүүлэх үйл явцад улстөрийн сонгуульт албан тушаалтнуудаас шууд хамаараад байдаггүй болгосон. Тэгэхээр, “авилгалыг” ядахдаа л төрийн албаны салбарт орж ирсэн улстөрийнхний халдаасан “балаг” гэдгээр дулимагхан ч болов тодорхойлж болох болж байгаа юм. Онолын хувьд, сонгогчид нь хээл хахуульд автсан улстөрчидтэй хариуцлага тооцож болдог бол, харин төрийн албан хаагчдыг хахуулдах болон хахуулдахыг нь хянах ёсгүй болж байгаа юм.

Төрийн албаны соёл

Өргөн утгаараа бол, АНУ-д улстөр ба төрийн албыг зааглаж өгдөг 4 гол хэрэгсэл бий. Нэгд, *сонгон шалгаруулалтын* явц. Төрийн албан хаагчдыг “төрийн албаны шалгалт”-ын дүнг харгалзан сонгодоогоороо улстөрийн сонгуульд нэр дэвшүүлэн гаргадаг үйл явцаас ялгаатай юм. Тиймээс ихэнхи төрийн албан хаагчид нь өөрсдийн ажил үүргийн хувиар сонгуульт албан тушаалтнуудаас үл хамааран оршино гэсэн үг. Хоёрт, төрийн албан хаагч нь нэгэнтээ томилогдсон бол төрийн хууль *ёсны хамгаалалтад* ордог. Хэн нэгэн албан хаагч удирлагынхаа үзэмж, хүслээр ажлаасаа халагдахгүй ба олонхи муж улсын болон холбооны засаг захиргааны аппаратын байгууллагуудад энэ тухай заасан дотоод журам бий Эдгээр журам нь төрийн албан хаагчдыг өөрийн байгууллагын удирдлагын шатанд эсвэл байгууллагын хүрээнд авилгал ба хууль бус аливаа үйлдлийг нь илрүүлсэнтэй холбогдуулан зүй бусаар шийтгүүлэхээс хамгаалахад чиглэсэн байна. Гуравт, *Ёсзүйн Дүрэм /кодекс/* АНУ-ын Төрийн Захиргааны Нийгэмлэг зэрэг нэр хүнд бүхий байгууллагуудаас гаргасан төрийн албан хаагчдын Ёсзүйн Дүрэм гэж байна³². Эдгээр байгууллагууд нь төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоож, захиргааны бүтцийн доторхи ажлын уялдаа холбоо, хариуцлагын тогтолцоог тодорхойлж өгсөн байдаг. Дөрөвт, төрийн захиргааны нэгдмэл соёл буюу “*төрийн албаны үзэл суртал*” гээчийг АНУ-д удаан боловч бий болгож чадсан явдал юм. Дээр өгүүлсэн дүрэм журам, заавар удирдамж нь чухал хэдий ч, үнэн хэрэгтээ аль ч байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах буюу оролцож чадахгүй билээ. Тиймээс л, хээл хахуулийн сүлжээг бий болгохгүй байх, түүнээс зайлсхийхийн тулд нэгдмэл үзэл сурталтай байхыг чухалчилж байгаа юм.

Тэгэхээр ямар ч байсан төрийн албаны доод, дунд шатандаа ёсзүйн доголдол, авилгал хээл хахуулиас ангижирсан гэж хэлэх боломжтой болоод

³² "Code of Ethics Law and Legal Definition," *U.S. Legal*, 2010, <http://definitions.uslegal.com/c/code-of-ethics/>

³² American Society for Public Administration, *Code of Ethics*, 2006, http://www.aspanet.org/scriptcontent/index_codeofethics.cfm

байгаа АНУ-ын хувьд төрийн албаны өнгө төрх ийм гэгээлэгээр төсөөлөгдөж байгаа бол манай орны хувьд төрийн албыг улстөрөөс ангид байлгахад жинтэй нөлөө үзүүлдэг эдгээр үзүүлэлтүүд ямархуу байгааг харья.

Сонгон шалгаруулалт. Эрхбиш “цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй” юм болохоор манай улс ч төрийн албанд шалгалт авч элсүүлдэг энэхүү журамд шилжээд багагүй хугацаа өнгөрч байна. “Төрийн албаны шалгалт”-ын дүнг үндэслэн төрийн тодорхой ажил, албан тушаалд авч ажиллуулах ажлыг 1995 онд зохион байгуулагдсан МУ-ын Төрийн Захиргааны Албаны Зөвлөл буюу 2002 оноос Төрийн Албаны Зөвлөл гэх байгууллага удирдан зохион байгуулж, тэрчлэн хяналт тавих, холбогдох зөрчил, эрхзүйн дутагдлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага болтлоо өргөжөөд байна. Төрийн албан хаагчийн шалгалт өнөөдөр манай улсын хувьд эхлэл төдий байгаагаас шалгалт өгч, мэдлэгээ үнэлүүлээд тэнцсэн нь ажлын байраа олж авдаг шударга, цэвэр “өрсөлдөөн”-ий зарчим тал тохой татдаг, нутаг нугын сэтгэлгээтэй манайхны хувьд дасал болоогүй үзэгдэл харагдаж байгаа нь зүйн хэрэг. Төрийн албан хаагчийн шалгалтанд төдийлөн ач холбогдол эс өгөн, нөгөө л муйхар аргаараа хэн, хаана, юу хийж байгаа, яаж аргалж гарыг нь хүндрүүлбэл, надад хэрэг болох бол гэдэг ужиг сэтгэлгээ амь бөхтэй хадгалагдаад байгаагын далд нэг шалтгаан нь төрийн албаны нэр хүнд юм. Өдөр тутмын сонин, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээллүүдэд анализ хийж төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэх явцад илэрч буй ёс суртахууны зөрчлүүдийг ерөнхийд нь багцалж үзвэл:

- Шинээр ажилтан авахдаа шалгалтад авсан оноог нь бус, танил талаа авах
- Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа уг албан тушаалд тавигдах шаардлагыг бус, түүнд оруулах гэсэн хүндээ тохируулах
- Төрийн албан хаагч аль нэгэн намд үйлчлэх
- Нас, хүйсээр ялгаварлан гадуурхах
- Улстөрийн нам, итгэл үнэмшлээр нь ялгаварлах
- Төрийн албаны хэвшсэн журмыг үл тоомсорлон шийдвэр гаргах
- Хамаатан садан, танил талдаа давуу байдал олгох, урамшуулал хөнгөлөлтөд түлхүү хамруулах

Үүнээс харахад шалгалтын оноог харгалзан үзэх гэдэг мөн л төдийлөн зохистой хэрэгжихгүй байгаа үзүүлэлтийн нэг болохыг харж болно. 1896 оноос Төрийн албан хаагчийн шалгалтийг хэрэгжүүлж эхэлсэн АНУ-ын хувьд энэхүү шалгалтыг зайлшгүй бий болгоход нөлөөлсөн нэгэн эмгэнэлт хэрэг 1881 онд болсон юм. АНУ-ын 20 дахь Ерөнхийлөгч Жеймс Гарфильдийн амийг бүрэлгэгч нь Ерөнхийлөгчийг дэмжсэнийхээ төлөө, төрийн албанд ажилд оруулахыг шаардаад, татгалзсан хариу сонсоод түүний амийг хөнөөсөн байлаа.³³ Энэ гэмт хэрэг төрийн албанд шалгалтаар элсдэг журмыг бий болгоход жинтэй

³³ “The Pendleton Civil Service Reform Act,” *Wikipedia*, http://en.wikipedia.org/wiki/Pendleton_Civil_Service_Reform_Act

нөлөөлсөн гэгддэг бөгөөд гэхдээ мэдээжийн хэрэг, тухайн үед газар аваад байсан төрийн бюрократ аппаратад бугшсан субъектив хүчин зүйлийг үгүй хийж, илүү объектив байдлаар албан хаагчдын сонгон шалгаруулалтад хандах зайлшгүй шаардлагатай ч мөн уялдаж байсан нь гарцаагүй. Тэгэхлээр манай орны хувьд энэ асуудалд хэрхэн хандвал зохистой вэ гэдэг асуулт урган гарч байна. Асуудлыг бугшуулж “хатиг” болтол нь даамжруулах уу, үгүй бол заавал ямар нэгэн эрсдэл дагуулж байж шийдэхээ хүлээх үү? Эсвэл хөгжлийн хурдаа нэмэхийн тулд нийтийн жишгийг дагасан нь дээр үү?

Хууль ёсны хамгаалалт. Төрийн албан хаагчдаас өөрийн удирдлага болон байгууллагын үйл ажиллагаанд гарч байгаа хууль бус үйлдэл, авилгал хээл хахууль, санхүүгийн зүй бус зарцуулалт, бүр цаашилбал, ажлын байран дах ялгаварлан гадуурхалт, эмнэлэг үйлчилгээний газрын зүй бус, зөрөөтэй хандлага ба үйлчилгээний тухай мэдүүлсэн тохиолдолд үзүүлэх хууль ёсны хамгаалалтыг энд багтааж ойлгоно³⁴. Дээр өгүүлсэнчлэн АНУ-ын хувьд эрхзүйн ийм зохицуулалтыг муж болон холбооны улсын хэмжээнд мөрдөх практик тогтож, шударга үнэний талд байж түүнийг илрүүлсэнийх нь төлөө тухайн ажилтаныг хувь хүнийх нь хувьд хамгаалалтад авах, мэдээллийн эх сурвалжыг нууцлах, шударга, зоримог үйлдлийнх нь төлөө урамшуулах ажил аль хэдийнээ хэрэгжээд эхэлсэн байна. Гэвч, асуудлыг эцэслэн шийдвэрлэж төгс төгөлдөрт хүрсэн гэж хэлэхэд эртдэнэ. Холбооны улсын төвшинд, муж улс бүр, тэр байтугай, байгууллагуудад ч харилцан адилгүй томъёолсон журмууд байгаа нь эргээд энэ төрлийн хэргийг зохицуулах, шийдвэрлэх асуудалд хүндрэл учруулахын зэрэгцээ хуулийн өмнө тэдгээр шударга иргэдийг өмгөөлөх хамгаалалтын цогц асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Манай улсын хувьд ч төрийн албаны дотоод хяналт нь төрийн албан хаагчын нийгмийн ухамсрыг идэвхжүүлэх нэгэн чухал хэлбэр болохын хувьд сөрөг үзэгдэлтэй тэмцэх, төрийн албаны шилдэг уламжлалыг өвлөн үлдээх, төрийн албаны удирдах чадвар, ажилтнуудын харилцааны соёл, хөдөлмөрийн зөв зохион байгуулалт, хэл ярианы соёл зэрэг олон цогц асуудлыг хамаарах баялаг асуудал билээ. Гэтэл, “хүний ул шагайгч”, “хошуугаа худалдагч”, “ховч, туршуул”, “-ний талын хүн” “бууны нохой” гэх зэрэг элдвээр элдвээр хоч зүүж, нүд үзүүрлэн, байх суух газаргүй болгосоор, нэг мэдэхэд л орчиндоо нэг эрүүл ухаантай, зөв сэтгэх хүнгүй болгож “нам дарж авдаг” хорон аргад нэвтэрхий болсоор байгааг хэн хүнгүй хэлүүлэлтгүй мэднэ. Энэ төрлийн хамгаалалт үгүйгээс, болсон явдлын бодит үнэнийг шударгаар мэдээлснээрээ хохирогч болохгүйн тулд хүн бүр амаа хамхиж, нүдээ аниж явахаас өөр аргагүйд хүрнэ. Ийм хамгаалалтыг нэн түрүүнд үзүүлдэг болсноор л нийгэм эрүүлжих бодит хөрс бий болох болов уу? Улс, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажлын хариуцлагаа ухамсарлана гэдэг ёс суртахуунлаг иргэний хийх л ёстой ажил. Тэгвэл нийгмийн хариуцлагыг бүхэлд нь идэвхжүүлэх хамгийн гол арга бол

³⁴ "Whistleblower Statutes," Law Library: American Law and Legal Information, 2010, <http://law.jrank.org/pages/11824/Whistleblower-Statutes.html>

юуны түрүүн, өөрийн ёс суртахууныг нээх явдал гэдэг. Ёс суртахууны хувьд өөрийгөө танина гэдэг, ёс суртахууны өндөр шаардлагыг ханган, үнэнч шударга, аливаад мэдрэмжтэй байж, өөрийгөө боловсруулах, хүнлэг байх зэрэг сайн сайхны төлөө хийх бүхий л үйл ажиллагаа орно. Мөн нийгмийн хариуцлагыг идэвхжүүлэх бас нэг арга нь үүргийн мэдрэмжийг төлөвшүүлэх явдал гэж үздэг. Төрийн албан хаагчын эрхэм үүрэг нь эх орныхоо өмнө хүлээх үүрэг байдаг. Энэ мэтчилэн шат дараалсан арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлж байж төрийн албаны нэр хүнд, түүний цэвэр тунгалаг байдлыг хамгаалж чадна.

Ёсзүйн Дүрэм. Ёсзүйн Дүрэм гэдгийг хамгийн ойлгомжтой байдлаар, өөрсдийн үйл ажиллагаандаа ёсзүйн сонголт хийхэд зориулсан заавар гэж болох юм. Мэргэжлийн шударга байдал, зарчимч чанар гэдэг олонхи ажилтан, албан хаагчдын талаархи итгэл үнэмшлийн тулгын чулуу гэж ойлгож болно. Үүнийг тухайн байгууллагын үйл ажиллагааны зарчим, мэргэжлийн стандарт, ёсзүйн үйл байдлын хөтөлбөр гэж ойлгож болно. Төрийн албан хаагчийн ёсзүй нь төрийн албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үүргийг биелүүлэхтэй холбоотой хэм хэмжээ, шаардлагаас бүрдэнэ. Төрийн албан хаагчийн ёсзүй нь мэргэжлийн ёсзүйд багтдагын хувьд ёсзүйн шинжлэх ухааны түгээмэл ойлголтуудын хүрээнд асуудлыг авч үзэн, ёс суртахууны хамгийн гол зүйлийг тусгасан ерөнхий ойлголтуудыг хэрэглэнэ. Тухайлбал, иргэнлэг чанар; эх оронч үзэл; үүрэг, хариуцлага; мэргэжлийн нэр төр; шударга ёс; зан суртахууны хамгаалалт г.м. Дээрхи ойлголтуудын ихэнхи нь төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагыг тодорхойлоход чиглэсэн байна. Төр чадамжтай, албан хаагчид нь ёс суртахуунтай байх нь төрт ёсны ариун байдал, дотоод нягтралаар хэмжигдэх бөгөөд түүнийг эрхэлж буй хүний шударга чанар, үнэнч байдал, боловсрол, мэдлэг, туршлагаас ихээхэн хамаардаг. Төрийн албан хаагчдын ёс суртахуун доголдоход төрийн албаны чадамж суларч, ард олны итгэл алдарч, хууль эрхзүй үнэгүйдэх явдал илэрнэ. Иймээс нэр төдий хууль журам баталснаар ажил урагшлахгүйг харгалзаж асуудлыг зоримог барьж авч тууштайхан хандах нь манай улсын хувьд нэн түрүүн хийх ажил болоод байна. Хамгийн энгийн ганц жишээг л дурдахад арав гаруй жил яригдсан УИХ-ийн гишүүний Ёсзүйн дүрэм 2009 оны 4 сард батлагдсан хэдий ч, түүнийг хэрэгжүүлэх хууль ёсны субъект УИХ-ын гишүүдийн ёсзүйн холбогдолтой асуудлыг шийдвэрлэх эрх бүхий Ёсзүйн Дэд Хорооны үйл ажиллагааны дүрмийг батлаагүй байгаа нь одоог хүртэл энэхүү асуудал бүрхэгдэх, эзэнгүйдэх, хяналтгүй оршиход хүргэж байна.

Төрийн албаны үзэл суртал. Босго тавих механизмд тооцогдох шалгалтын хэлбэр, мэдээлэгчийг хамгаалах эрхзүйн журам, үйл ажиллагааны зарчим болох ёсзүйн дүрэм зэрэг дээр дурдсан нэр бүхий олон ажил нь төрийн албыг улстөрөөс зааглахад чухал хэдий ч нүд салгалгүй хянахын дайтай байж чадахгүй гэдэг нь ойлгомжтой. Хэрэв төрийн бюрократ аппарат бүхэлдээ хахуульд идэгдчихвэл, түүнийг ёс төдий хууль, журмаар зохицуулаад явна гэдэг утгагүй болно. Тиймээс, төрийн захиргааны бүтцийг үр ашигтай ажиллуулахыг хүсвэл, “төрийн албаны үзэл суртал” амин чухал билээ. Энэ нь төрийн албан

хаагчдын өөрсдийн дотоод итгэл үнэмшлийн систем юм³⁵. Шилдэг сайн төрийн албанд амин чухалд тооцогдох тийм үнэт зүйлсийг агуулснаар төрийн албанд гарч болох гажуудал, алдааны эрхзүйн болон мэргэжлийн үр дагаврыг тодорхойлж, улмаар түүнээс сэргийлэх боломжтой болно гэсэн үг.

Эцэст нь хэлэхэд, энэ бүх эрхзүйн болон соёлын, албан болон албан бус олон аргууд нь бүхэлдээ төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тодорхой үүргийг гуйвалтгүй хэрэгжүүлэхэд л чиглэж байгаа билээ. Америкт ч төрийн албанд алдаа дутагдалтай зүйл гардаг, үв тэгш загвар гэж хэлж хараахан болохгүй ч, төрийн албыг нь авилгал, хээл хахуульд хаа сайгүй, нэвт идэгдсэн гэж хэлж харин хэрхэвч болохгүй. Тэгэхээр, АНУ-д төрийн алба болон улстөрийн системийн хооронд мэдэгдэхүйц зааг ялгаа бий гэдгийг дурдах нь зүйтэй. Ийм болохын төлөө бид ч бас оролдоод үзэх ёстой.

Сонгуульт албан хаагчдын соёл

АНУ-ын улстөрчид буюу сонгуульт албан хаагчдын соёл төрийн албан хаагчдынхаас нэлээд ялгаатай. Америкийн улстөрчдийг бүхэлд нь “хахуульд автсан” гэх нь шударга бус хэдий ч, ямар нэг дуулиант явдлуудаар баян байдаг гэвэл үнэнд нийцнэ. Дурдагдаж буй төрийн албан хаагчдын болон сонгуульт албан хаагчдын соёлын заагыг барьж, сонгуулийг тойрсон эрээн бараанаас төрийн аппаратыг бохирдуулахгүй авч үлдэхийн тулд эдгээрийн эргэн тойронд буй зарим нэгэн ойлголтуудыг тодруулах нь чухал юм.

АНУ-д авилга хээл хахуулийн хэрэгт ихэвчлэн улстөрчид холбогддогос тэд хэвлэл мэдээллийнхний анхаарлын төвд байдаг. Америкийн улстөрчдөд тулгардаг ёс суртахууны асуудлууд заримдаа давхцдаг ч, үндсэнд нь хоёр үндсэн хэсэгт хувааж болох юм. Эхнийх нь, “секс скандал” буюу гэр бүлээс гадуурхи бэлгийн харьцааны талаархи маргаан. Хоёрдах нь, зүй бусаар мөнгө олох, сангийн мөнгийг хууль бусаар ашиглах, өөрийн болон танил тал, гэр бүлийнхнийхээ албан тушаалыг санхүүгийн сонирхлоор ашиглах буюу хээл хахууль авах зэрэг санхүүгийн зөрчил. Эдгээрт холбогдох сүүлийн үеийн дуулиант хэргүүдээс дурдвал:

Өмнөд Каролина мужийн амбан захирагч, намын өсч яваа залуу халаад тооцогдож байсан Марк Санфорд Эдийн засгийн хөгжлийн бага хурлын үеэр танилцсан Аргентины өргөн хэрэглээний барааны брокер Мариа Белен Чапуртай гэр бүлээс гадуур харьцаа тогтоосон нь илрэв. Гэр бүлийн үнэт зүйлсийг идэвхтэй хамгаалахаар өөрийн улстөрийн гараагаа эхлэж байсан БННамын гишүүн энэ хүн тухайн үедээ гэр бүлтэй, хэд хэдэн хүүхэдтэй ч байлаа. Тэрбээр асуудалд холбогдоод байхдаа, өөрийн гэр бүлийнхэн болон албаныхандаа ямар ч хэл өгөлгүй муж дамжин алга болж байв. Аялалаасаа

³⁵ Gerald E. Caiden, “Public Maladministration and Bureaucratic Corruption,” 1980, sunzi.lib.hku.hk/hkjo/view/52/5000170.pdf

буцаж яваад онгоцны буудал дээр тааралдсан сурвалжлагчид хаагуур явсанаа нууж худал мэдээлэл өгч байв³⁶.

2006 онд, АНУ-д олныг шуугиулсан өндөр албан тушаалтнуудын оролцсон олон хэргүүд гарч байв. Ерөнхийлөгч Жорж Буш, Олонхийн бүлгийн ахлагч Том Дилэй зэрэг БНН-ын олны танил нэлээдгүй улстөрчидтэй сүлбэлдэн лобби хийдэг байсан Жак Абрамов нь АНУ-ын өндөр зэрэглэлийн нэгэн лобби фирмд ажиллаж байхдаа Конгрессын олон ч гишүүдийг элбэг дэлбэг амралт, үнэтэй бэлэг сэлтээр татаж нэр нүүр олж байжээ.

Уугуул Америкийн дөрвөн овогт мөрийтэй тоглоомын лиценз олж өгөх асуудалд орооцолдон өөрийн амьдралаа сүйдэлсэн Абрамов тэдгээр овгийнхноос олон сая долларыг лиценз гаргуулах лоббийн кампанит ажил зохион байгуулна хэмээн луйвардан өөрийн халаасаа түнтийлгэжээ. Абрамов мөн Конгрессын хэд хэдэн гишүүдэд хууль бус бэлэг сэлт, мөнгөн дэмжлэг үзүүлж байв. Түүнээс хахууль авсан хэргээр Конгрессын гишүүн Боб Неи шоронд суухад хүрч байлаа. Хахууль болон үйлдсэн бусад гэмт хэргийнхээ улмаас Абрамовт холбооны улсын шоронд дөрвөн жил хоригдох ялаар шийтгүүлжээ.

2006 онд Луйзианна мужаас Конгресст сонгогдсон Ардчилсан Намын гишүүн Уильям Жефферсоны Виржиния муж улсад байх гэрийнх нь хөргөгчөөс 1000 долларын дэвсгэртээр толгойлсон 90,000 ам доллар бэлнээр гарч ирсэнээр эрүү үүсгэгдэв. Тэрхүү мөнгийг и-Гейт компанийг төлөөлж байгаа гэх Холбооны Мөрдөх Товчооны мэдээлэгч өгсөн хэмээн мэдүүлсний дээр, Африкийн хэд хэдэн улсын засгийн газартай и-Гейт компаний хийх нэгэн өндөр ашигтай гэрээнд дэмжлэг үзүүлэхэд ашиглана гэж авсан ажээ. Ийнхүү Жефферсоныг хээл хахуулийн хэргээр 11 зүйл ангиар ял хүлээлгэн 13 жилээр шоронд ял эдлэхээр шийтгүүлээд байгаа ажээ³⁷.

Монгол улсын хувьд ч, улстөрчдийн нэр оролцсон олон тооны авилгалын дуулиан байдгаас дурдвал Алт дилерийн хэрэг, Айбекс групп, Молам корпорацийн гэрээ, Улсын Их дэлгүүрийн хувьчлалын асуудал, Бороо гоулд компанитай байгуулсан тогтвортой байдлын гэрээний асуудал, хадгаламж зээлийн хоршоодын дампуурал, 2 тэрбум төгрөгийн шатхууны зээлийн асуудал, гадаадын зээл тусламжийг зүй бусаар ашигласан асуудлууд зэргээр жагсаалт нэлээд урт үргэлжлэх болно.

Гэвч эдгээр хэргүүд дотроос шүүхээр шийтгүүлсэн нь үгүй гэдгийг бид мэднэ. Харин Монголын улстөрчдийн хувьд гэр бүлээс гадуур тогтоосон бэлгийн харьцааны талаархи яриа мэр сэр дуулддаг ч, хууль шүүхийн өмнө дуудагдах хүртлээ даамжирсан нь үгүй буюу дор хаяж л олны нүднээс түүнийгээ далд байлгаж чаддаг бололтой.

³⁶ Tim Padgett, "Sanford's Sex Scandal: Assessing the Damage," *Time*, 25 June 2009.

³⁷ Geov Parrish, "Making Sense of the Abramoff Scandal," *Alternet*, 20 December, 2005.

АНУ дах авилгалын талаархи

олон нийтийн санаа бодол

Дээр дурдсанчлан, улс төрийн дуулиант хэргүүд Америкийн хэвлэлийнхний анхаарлыг асар их татдаг. Дээр дурдсан хэргүүд нь бүгд сонин хэвлэл, интернэт сайтууд, кабелийн телевизийн мэдээний сувгаар дэлгэрэнгүй нийтлэгдэж байв. Олон тооны гэмт хэргүүд, тэдгээрийг түгээх мэдээллийн агентлагуудын дүнд улстөрчдийг нэлээдгүй авилгалд автсан, улстөрийн систем дэх авилгалын асуудлыг авч хэлэлцэх цаг болжээ гэж үзэх олны итгэл үнэмшил бэхжихэд хүрээд байна.

олон нийтийн санаа бодлыг тандах “Пью” агентлагийн 2006 оны нэгдүгээр сард явуулсан судалгаагаар, судалгаанд оролцогчдын 81 % нь “Лоббичид Конгрессийн гишүүдэд хахууль атгуулдаг” гэдэгтэй санал нэгдсэн бол, 38 % нь “сонгогчидоо бус, хандивлагчдын үгийг илүү сонсдог”, 20 % нь “Конгрессийн гишүүдийг мөнгөний төлөө сонгогчдын саналыг худалддаг” гэж үздэгээ илэрхийлсэн байна.

Абрамов, Дилей нар БННамын гишүүн байсанчлан, БННамынхан АНамынхнаас 14-31%-иар илүү авлигад автсан гэж үзжээ. Гэхдээ, санал асуулгад оролцогчдын олонхи нь буюу 43 % нь хоёр нам хоёулаа хээл хахуульд автсан гэжээ. Өөрөөр хэлбэл, Америкчууд Конгрессийн шударга, зарчимч байдлын талаар нэлээд таагүй бодолтой байдгаа илэрхийлжээ. Түүнчлэн, дээрхи оролцогчдын 54 % “Конгрессийн гишүүдийн авилгад өртөх нь урьд урьдаас ихэссэн” гэсэн нь энэ асуудал улам бүр ужиг болж байгааг харуулж байна³⁸.

2008 оны арванхоёрдугаар сард, “Галлоп” судалгааны төвөөс явуулсан янз бүрийн ажил мэргэжлийн “шударга”, “ёс суртахуунлаг” байдлын төвшинг тогтоох судалгаанд,сувилагчид 84%, Сенатын гишүүд 35%, Конгрессын гишүүд 40%, мужийн амбан захирагч нар 22-26 %, хуучин машины худалдаачид 7% санал авсан бол, асуулгад оролцогчдын 52% нь сонгуульт албан хаагчдын “нэлээн цөөн” хэсэг нь “авилгад идэгдсэн” гэсэн бол, 5 % нь “тэд бүгд авилгад автсан” гэж үзэж буйгаа харуулжээ³⁹.

Төрийн алба гэдэг олон нийтийн санаа бодлыг судлагчдын зүгээс асуудаг хэвшмэл асуулгын нэг байхаа больжээ. Ихэнхи Америкчуудын улстөрийн ухамсраас төрийн албаныхны авилгалын асуудал аль хэдийн арчигдсан бөгөөд үүнийг санал асуулгад оруулах нь ч төдийлөн чухал биш болсоныг судалгааны

³⁸ Pew Research Center for People and the Press, “Bush a Drag on Republican Midterm Prospects: Hillary Seen as Leader of Democratic Party,” *Survey Reports*, 9 February, 2006, file:///Volumes/HP%20v125w/bush-a-drag-on-republican-midterm-prospects.htm.

³⁹ Joseph Carroll, “Americans’ Satisfaction With the State of the Nation
Americans mostly Dissatisfied Because of Economic Factors” *Gallup online*, 3 October 2007, file:///Volumes/HP%20v125w/Americans-Explain-Their-Satisfaction-State-Nation.aspx.htm.

үзүүлэлтүүд харуулах болов. Гэхдээ, энэ нь Америкчууд төрийн албан хаагчдын үйл байдалд бүхэлдээ сэтгэл хангалуун байдаг гэсэн үг мэдээжийн хэрэг биш бөгөөд “бюрократ аппарат” гэдэг нь нэлээд холимог байдлаар буюу “авилгал, хээл хахууль” гэхээсээ, өөрсдийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, сонирхолд мэдрэмжгүй ханддаг, үр өгөөжтэй бус гэдэг байдлаар илүүтэй ойлгогдож байна. Америкчуудын олонх нь Шуудан Холбоо, Авто Тээврийн Яам, Ажилгүйдлийн Албаны үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус ханддаг. Засгийн газрын үйл ажиллагаанд ерөнхийдөө сэтгэл хангалуун бус ханддаг нь эргээд төрийн бюрократ аппаратын талаархи ойлголтод нь нөлөөлөхөд хүргэдэг байна.

Авилгалын талаархи Монголын

олон нийтийн санаа бодол

Дээр дурдсанчлан, авилга, хээл хахуулийн асуудалд Монголын улстөрчид багагүй нэр холбогддог ч, хуулийн цоорхойг ашиглах, хууль шүүхийнхнийг өөрийн эрх ашигт үйлчлүүлэх, хуулийг гууль болгох олон аргаар хуулийн гадуур явсаар байна. Харин Монгол төрийн өнгө төрхийг тодорхойлогч-төрийн албан хаагчдын ёсзүйн байдал ямархуу төвшинд байгааг судалгаанаас тоймлон авбал, 2006 оны Удирдлагын Академийн “Төрийн албаны ёсзүй, үнэлэмж”-ийн талаархи судалгаанд хамрагдагсдын үнэмлэхүй олонхи болох 87.7 % нь “Төрийн албыг мэргэжлийн өндөр төвшиний бэлтгэлтэй хүн хаах ёстой” гэсэн хариулт өгсөн нь ард түмний дунд төрийн захиргааны албадыг, мэргэшсэн, шударга ёс суртахуунтай байх хүлээлт буйг үзүүлж байна. Хэдий тийм ч, ард түмний дунд төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд сэтгэл дундуур байдал ажиглагдаж байгаа нь дээрхи судалгаанд оролцогчдын 74.2 % нь төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдалд шүүмжлэлтэй хандсанаар илэрч байна⁴⁰. Дээрхи асуулгад оролцогчид төрийн албан хаагчдын ёсзүйгүй байдал орон нутаг дах төрийн захиргааны доод төвшинд элбэг байдаг гээд, тэдэнд хамгийн доогуур үнэлгээ өгчээ. Гэвч нөгөө талаар, дээд төвшиний албан хаагчдын ёсзүй, авилгалын талаар мэдэхгүй байгаа нь тэдэнд илүү ойр, шууд харьцдагаас доод түвшинд ажиллаж байгаа төрийн албан хаагчдад шүүмжлэлтэй хандахад хүргэж байна. Харин дээд шатанд авлига, хээл хахуул илүү хийсвэр шинжтэй ойлгогдож байгаа нь төрийн албан хаагчид дээд шатандаа илүү шударга, үнэнч байдаг гэсэн үг огт биш бөгөөд харин ч, шууд, нээлттэй байдал хомс байгаагаас бодит мэдээллийг олж авч чадахгүй байгаагаар тайлбарлах ёстой болов уу.

Авилгалыг өөгшүүлэгч хүчин зүйлсийн талаархи иргэдийн санаа бодлыг тандахад 67.2 % авилгалын эсрэг хууль хангалтгүй, буюу зохистойгоор хэрэгжүүлж чадахгүй байгааг тэмдэглэсэн нь асуудлын гол нь хууль хэрэгжүүлэх байгууллагууд - захиргааны аппаратдаа ч биш, хууль, эрхзүйн системд ч байгааг

⁴⁰ “Төрийн албаны ёсзүйн, үнэлэмж, шинжилгээ, дүгнэлт” судалгаа, Удирдлагын Академи. УБ.2006.,

харуулж байна⁴¹. Үүнийг нэг тодорхой жишээг дурдахад, Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн Хуулиар олгогдсон цагаатгах, өршөөл үзүүлэх эрхийн дагуу хамгийн сүүлд л гэхэд, 2009 оны 7 сарын 9-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулинд Авилгалтай Тэмцэх Газрын харьяаллаар шалгадаг авилгал, албан тушаалын холбогдолтой гэмт хэргийн 80 хувь хамрагдаж, улмаар 2009 оны 6 сарын 24-нөөс өмнө үйлдэгдсэн авилгал, хээл хахуулийн холбогдолтой аливаа хэргийг хэрэгсэхгүй болгосноор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эрхзүйн орчин хуулиар бий болгосон⁴². Ийнхүү хууль эрхзүйн систем нь авлигын эсрэг хуулиа хэрэгжүүлэх сонирхолгүй буюу чадамжгүй бол асуудлыг шийдвэрлэх тогтвортой, үр дүнтэй арга замыг хайна гэдэг нэн бэрхшээлтэй болно. Энэ нь төрийн албаны цэвэр, тунгалаг байдалд ард түмнийг итгүүлэхэд төвөгтэй болоход хүргэнэ.

АНУ дах өөрчлөлтийн оролдлого

2004-2006 онуудад өрнөсөн Конгрессын үйл ажиллагаа, нэр хүндийг ганхуулахад хүргэсэн ёсзүйн олон асуудлууд нь холбооны улсын хэмжээнд асуудлыг хянах үүднээс зарим нэгэн дорвитой алхам хийхэд хүргэсэн. Төлөөлөгчдийн Танхимын дарга Нэнси Пелосийн санаачилгаар “Шударга Удирдлага ба Нээлттэй Засаглал” хуулийн төслийг өргөн барьсанаар, лобби бүлгийнхнээс Конгрессын гишүүдэд өгдөг бэлэг сэлтийг хязгаарлах, лобби бүлгийнхнийг үйл ажиллагааныхаа талаар нарийвчилсан тайлан гаргахыг шаардах, төрийн алба хашиж байсан хүмүүст албан үүргээ хүлээлгэн өгсөнийхээ дараа шууд лобби фирмд ажил эрхлэхийг нь хориглох зэрэг заалтуудыг тусгасан. Мөн Пелоси гаднаас ирэх санал гомдлыг судлах, шаардлагатай гэж үзвэл шалгалт явуулах хүртэл эрхтэй бие даасан ёсзүйн хороог байгуулах санлыг оруулсан байсан нь Конгрессоос хараат бус ажиллах ёсзүйн бие даасан субъектийг байгуулах тухай Конгрессын удирдлагын зүгээс оруулж ирсэн анхны санал байв. АНУ-ын Конгрессын 110 дугаар чуулганы хуралдаанаар хуулийн төслийг баталсан нь дээр дурдагдсан хорооны асуудлыг багтаагаагүй ч, Конгрессын гишүүд болон лобби бүлгийнхний зарим тодорхой үйл ажиллагааг хязгаарласны дээр, илүү нээлттэй, тунгалаг болгоход чиглэсэн алхам болж чадсан юм⁴³.

ДҮГНЭЛТ

АНУ дах авлигалын асуудлын цөм нь сонгуульт албан тушаалтнууд болох тул өөрчлөлтийг тэдэн рүү чиглүүлэх хэрэгтэй юм. Монгол орны хувьд,

⁴¹ “Project ‘On pro-and anti-corruption factors survey analysis’ completed”, Asia Research Network Vol.4 No1, 2007”

⁴² “Ч.Сангарагчаа: Төрийн байгууллагыг улстөрийн аргаар дөрлөж болохгүй”. “Өнөөдөр” сонин. А6 тал. №229., 2009/10/06

⁴³ Sourcewatch, Center for Media and Democracy, “Prospects for Ethics Reform in the 110th Congress,” <http://www.sourcewatch.org/index.php?title=Prospects-for-Ethics-Reform-in-the-110th-Congress>.

шинэчлэлтийг захиргааны аппарат болоод хууль эрхзүйн актууд, тэдгээрийн биелэлтийг хянах механизм, мөн мэдээжийн хэрэг улс төрчид рүү чиглүүлэх хэрэгтэй байна. 2006 оны судалгаагаар, асуулгад оролцогчдын 36.5 % нь зохих хуулийн дагуу авилгад өртсөн албан хаагчдыг шийтгэх нь зүйтэй гэсэн бол, 36.3 % авлигын эсрэг илүү хүчтэй чанга хууль хэрэгтэй, хуулийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна гэжээ.

Хоёр орны ард иргэдийн дунд өөрсдийн улстөрийн систем дэх авлигын асуудалд нэлээд нухацтай хандаж байгаа нь харагдаж байгаа бөгөөд АНУ-ын хувьд хардлагад өртөгсөд нь улстөрчид байгаа бол, Монгол орны хувьд улстөрчдөөс гадна төрийн албан хаагчид, эрхзүйн систем ч үүнд орж байна. Аль ч орны хувьд авилгал, ёс суртахуунгүй байдлаас үүдэх олон асуудлыг, мөн тэдгээрт хандах олон нийтийн санаа бодлыг тусгах дорвитой арга замыг эрэлхийлэх хэрэгтэй байна. Авилгал, түүний бүхий л хэлбэр нь ардчилсан засаглалд заналхийлэх аюул билээ.

Ашигласан ном, веб сайтын жагсаалт

1. Mike Royko, *Boss: Richard J. Daley of Chicago* (New York: Plume Books, 1988).
2. "The Pendleton Civil Service Reform Act," *Wikipedia*, http://en.wikipedia.org/wiki/Pendleton_Civil_Service_Reform_Act
3. "Whistleblower Statutes," Law Library: American Law and Legal Information, 2010,
4. <http://law.jrank.org/pages/11824/Whistleblower-Statutes.html>
5. "Code of Ethics Law and Legal Definition," *U.S. Legal*, 2010, <http://definitions.uslegal.com/c/code-of-ethics/>
6. American Society for Public Administration, *Code of Ethics*, 2006, http://www.aspanet.org/scriptcontent/index_codeofethics.cfm
7. Gerald E. Caiden, "Public Maladministration and Bureaucratic Corruption," 1980, sunzi.lib.hku.hk/hkjo/view/52/5000170.pdf
8. Tim Padgett, "Sanford's Sex Scandal: Assessing the Damage," *Time*, 25 June 2009.
9. Geov Parrish, "Making Sense of the Abramoff Scandal," *Alternet*, 20 December, 2005
10. Nicholas Thompson, "The Tom De Lay Scandals," *Slate*, 7 April 2005.
11. Carl Hulse, "For Democrats, a Scandal of Their Own," *The New York Times*, 23 May 2006.
12. "The Gonzales Scandal: 101," *Gather*, March 19, 2007, <http://www.gather.com/viewArticle.action?articleId=281474976936148>
13. Pew Research Center for People and the Press, "Bush a Drag on Republican Midterm Prospects: Hillary Seen as Leader of Democratic Party," *Survey Reports*, 9 February, 2006, <file:///Volumes/HP%20v125w/bush-a-drag-on-republican-midterm-prospects.htm>.
14. Joseph Carroll, "Americans' Satisfaction With the State of the Nation

15. Americans mostly Dissatisfied Because of Economic Factors” *Gallup online*, 3 October 2007, <file:///Volumes/HP%20v125w/Americans-Explain-Their-Satisfaction-State-Nation.aspx.htm>.
16. Lydia Saad, “Iraq and Economy Are Top Issues for Voters,” *Gallup online*, 13 February 2008, <file:///Volumes/HP%20v125w/Americans-Explain-Their-Satisfaction-State-Nation.aspx.htm>.
17. Lydia Saad “Blagojevich Scandal Feeds into Public Skepticism,” *Gallup online*, 23 December 2008, <file:///Volumes/HP%20v125w/Blagojevich-Scandal-Feeds-Into-Public-Skepticism.aspx.htm>.
18. Sourcewatch, Center for Media and Democracy, “Prospects for Ethics Reform in the 110th Congress,” <http://www.sourcewatch.org/index.php?title=Prospects-for-Ethics-Reform-in-the-110th-Congress>.
19. “Global Corruption Barometer-2009”, Transparency International
УИХ-ын 2008 оны сонгуульд сонгогдогчдын болон УИХ-ийн гишүүдийн хөрөнгө, орлогын байдлын мэдүүлэг <http://www.iaac.mn/>
20. “Project ‘On pro-and anti-corruption factors survey analysis’ completed”, Asia Research Network Vol.4 No1, 2007”
21. “Төрийн албаны ёсзүйн үнэлэмж, шинжилгээ, дүгнэлт” судалгаа, Удирдлагын Академи. УБ.2006.,
22. Төрийн албаны тухай хууль. <http://www.legalinfo.mn/>
23. Авлигын эсрэг хууль <http://open-government.mn/lawsnews/>
24. Independent Authority Against Corruption of Mongolia <http://www.iaac.mn/>

Abstract

Public Officials’ Ethics: The U.S. and Mongolia

The paper is a preliminary comparative analysis of civil service and elected officials’ ethics and culture issues in the U.S. and Mongolia. Since this is the first such comparison that has been made of these two systems on this issue, the paper is more designed to open debate than to draw definitive conclusions. The basic premise of the paper is that there are some interesting parallels, but also important divergences, between how corruption is perceived in the U.S. and Mongolia. Corruption is an important issue in each nation, but the issues are somewhat different in each case.